



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 325

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, "Ховд дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8.4.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны 2018 оны 3/254 дугаар албан даалгавар, Эрчим хүчний сайдын 2018 оны А/544 дугаар албан бичгийн дагуу "Ховд дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийд 2018 онд зайлшгүй хийгдэх ажилд шаардлагатай хөрөнгө оруулалт болох 590,000,000.00 (таван зуун ерэн сая) хүртэлх төгрөгийн зээлийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зээл, зээлийн хүүгийн нөхцөлийг судлан арилжааны банктай байгуулах эрх олгохыг "Ховд дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

